



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2013.03.13 № A-1/293

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Банкны салбар дахь Засгийн газрын цэвэр зээлийн 2013 оны 4 дүгээр улирлын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудас.

Хувийг: Сангийн яаманд

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

Мажинзаа в.
Сүхүүрэг *Бүрэлд*

14 *0863*
2014.03.20

ТАНИЛЦУУЛГА

Банкны систем дэх Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)

Төв банк болон банкуудын нэгдсэн дүнгээр 2013 оны IV улирлын эцэст Засгийн газрын өр төлбөр 1823.0 тэрбум төгрөг, хөрөнгө 2879.0 тэрбум төгрөг болж, ЗГЦЗ-ийн хэмжээ -1056.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь ЗГЦЗ өнгөрсөн улирлаас 1221.2 тэрбум төгрөгөөр буюу 53.6 хувиар өссөн үзүүлэлт байлаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Банкны систем дэх ЗГЦЗ (Монголбанкийг оруулсан дүн) (тэрбум ₮)

Хөрөнгө	IX.30	XII.30	Өөрчлөлт	Өр төлбөр	IX.30	XII.30	Өөрчлөлт
Төсвийн харилцах	2 006,6	1 268,2	(738,4)	ЗГҮЦ	1 327,8	1 780,3	452,5
Төгрөгийн	448,7	807,1	358,5	Богшино хугацаатай	570,1	393,0	(177,1)
Валютын	1 557,9	461,1	(1 096,8)	Дунд хугацаатай	757,7	1 387,3	629,6
Төгрөгийн нөөц	373,2	386,4	13,2	ЗГ-т олгосон зээл	-	-	-
Нийгмийн даатгал	470,8	565,6	94,8	Бусад	38,9	42,7	3,8
ЗГ-ын санхүүжилт	563,1	540,1	(23,0)				
Бусад	230,2	118,7	(111,5)				
1.Нийт	3 643,9	2 879,0	(764,9)	2.Нийт	1 366,7	1 823,0	456,3
			ЗГЦЗ (2-1)		(2 277,2)	(1 056,0)	1 221,2

Банкны систем дэх Засгийн газар (ЗГ)-ын нийт өр төлбөр мөн оны 3 дугаар улирлаас 456.3 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар өссөн бол ЗГ-ын нийт хөрөнгийн хэмжээ 764.9 тэрбум төгрөгөөр буюу 21.0 хувиар буурсан байна. ЗГ-ын өр төлбөрийн өсөлтийг банкуудын эзэмшиж буй ЗГҮЦ-ны 452.5 тэрбум төгрөгийн өсөлт тайлбарлаж байгаа бол Монголбанкин дахь ЗГ-ын валютын харилцах данс 1096.8 тэрбум төгрөгөөр буурсан нь ЗГ-ын хөрөнгө буурахад голлон нөлөөлжээ.

Банкны систем дэх ЗГ-ын нийт өр төлбөр банкуудад байршиж байгаа бол хөрөнгийн 58.8 хувь нь Монголбанкинд, 41.2 хувь нь банкуудад байршиж байна.

Төв банкин дахь ЗГЦЗ

Засгийн газар тайлант улиралд Монголбанкнаас зээл авах, ЗГҮЦ худалдах хэлбэрээр санхүүжилт аваагүй бөгөөд Төв банкинд өр төлбөргүй байна. Улсын төсвийн төгрөгийн харилцах 358.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн хэдий ч, Чингис бондын хөрөнгийн зарцуулалтын улмаас ЗГ-ын валютын харилцах 1096.8 тэрбум төгрөгөөр буурсан нь ЗГ-ын нийт хөрөнгийн хэмжээ 732.5 тэрбум төгрөгөөр буурах шалтгаан болжээ. Тиймээс Төв банкин дахь ЗГЦЗ өмнөх улирлаас 732.5 тэрбум төгрөгөөр буюу 30.2 хувиар өсч, -1.7 их наяд төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)

Хөрөнгө	IX.30	XII.30	Өөрчлөлт	Өр төлбөр	IX.30	XII.30	Өөрчлөлт
Төсвийн харилцах	2 006,6	1 268,2	(738,4)	ЗГҮЦ	-	-	-
Төгрөгийн	448,7	807,1	358,5	ЗГ-т олгосон зээл	-	-	-
Валютын	1 557,9	461,1	(1 096,8)	Бусад	-	-	-
Төгрөгийн нөөц	373,2	386,4	13,2				
Бусад	45,5	38,2	(7,3)				
1.Нийт	2 425,3	1 692,8	(732,5)	2.Нийт	-	-	-
			Төв банкин дахь ЗГЦЗ (2-1)		(2 425,3)	(1 692,8)	732,5


Монголбанкин дахь ЗГ-ын нийт хөрөнгийн 47.7 хувь нь улсын төсвийн төгрөгийн харилцах, 27.7 хувь нь төгрөгийн нөөцийн дансанд, 22.8 хувь нь валютын харилцахад, 2.3 хувь нь бусад төрлийн дансанд¹ байна (Зураг 1).

Зураг 1. Төв банкин дахь ЗГ-ын хөрөнгө



Зураг 2-оос харахад, 2011 оны 6 дугаар сараас 2012 оны эцэс хүртэл Монголбанкн дахь ЗГЦЗ-ийн өөрчлөлтийг улсын төсвийн төгрөгийн харилцах дансны өөрчлөлт голлон тайлбарлаж байв. Харин 2012 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн газар 1.5 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах дээр амжилттай арилжаалж, тус бондын мөнгө Монголбанкн дахь улсын төсвийн валютын харилцах дансанд орсон нь ЗГЦЗ огцом буурах шалтгаан болжээ. Харин Чингис бондын хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор 2013 оны 5 дугаар сараас 12 дугаар сар хүртэл улсын төсвийн валютын харилцах огцом буурч, ЗГЦЗ-ийн хэмжээ өссөн байна.

Зураг 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



Засгийн газар 2013 оны 1 дүгээр сараас хойш Монголбанкнаас зээл аваагүй бол 2013 оны 7 сард Монголбанк өөрийн эзэмшиж байсан 113.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг Улаанбаатар хотын банкинд худалдсанаар Монголбанкнд өр төлбөргүй болжээ.

Банкууд дахь ЗГЦЗ

Банкууд дахь ЗГ-ын өр төлбөрийн хэмжээ өмнөх улирлаас 456.3 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар нэмэгдсэн бөгөөд хөрөнгийн хэмжээ 32.4 тэрбум төгрөгөөр буюу 2.7 хувиар буурчээ. Ингэснээр ЗГЦЗ-ийн хэмжээ 2013 оны 3 дугаар улирлаас 488.7 тэрбум төгрөгөөр буюу 3.3 дахин өсч, 636.8 тэрбум төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 3).

¹ Бусад төрлийн данс – Монголбанкн дахь улсын төсвийн валютын нөөцийн данс, төслийн данс, KFW-ын данс, хуримтлуулж тооцсон хүүний өглөг.

Хүснэгт 3. Банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)

Хөрөнгө	IX.30	XII.30	Өөрчлөлт	Өр төлбөр	IX.30	XII.30	Өөрчлөлт
Нийгмийн даатгал	470,8	565,6	94,8	ЗГҮЦ	1327,8	1780,3	452,5
ЗГ-ын санхүүжилт	563,1	540,1	-23,0	Бусад	38,9	42,7	3,8
Бусад	184,7	80,5	-104,2				
1.Нийт	1 218,6	1 186,2	(32,4)	2.Нийт	1 366,7	1 823,0	456,3
Банкууд дахь ЗГЦЗ (2-1)					148,1	636,8	488,7

Нийт өр төлбөр ийнхүү өссөн нь ЗГ-аас улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөх зорилгоор банкуудад 452.5 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсантай холбоотой байна. ЗГ-ын банкуудад байршуулсан төгрөгийн хугацаатай хадгаламж 70.3 тэрбум төгрөгөөр буурсан нь ЗГ-ын хөрөнгийн өөрчлөлтийг тайлбарлаж байна.

Банкууд дахь ЗГ-ын өр төлбөрийн 21.6 хувийг богино хугацаатай ЗГҮЦ², 76.1 хувийг дунд болон урт хугацаатай ЗГҮЦ³, 2.3 хувийг бусад төрлийн өр төлбөр⁴ эзэлжээ. ЗГ-ын нийт хөрөнгийн 47.7 хувь нь нийгмийн даатгал, 45.5 хувь нь ЗГ-ын санхүүжилт, 6.8 хувь нь бусад төрлийн хөрөнгө⁵ байна (Зураг 3а, 3б).

Зураг 3а. Банкууд дахь ЗГ-ын өр төлбөр



Зураг 3б. Банкууд дахь ЗГ-ын хөрөнгө



Банкууд дахь ЗГЦЗ-ийн хэмжээ 2011 оны 7 дугаар сараас 2012 оны 5 дугаар сар хүртэл тогтмол буурч байсан нь засгийн газрын санхүүжилтийн өсөлттэй холбоотой байсан бол 2012 оны 12 дугаар сараас эхлэн ЗГҮЦ-ыг Монголбанкаар дамжуулан банкуудад арилжаалах болсноор хэмжээ нь тогтмол өсч, ЗГЦЗ огцом нэмэгдэх шалтгаан болсон байна. (Зураг 4)


² 1 жил хүртэл хугацаатай ЗГҮЦ

³ 1-ээс дээш жилийн хугацаатай ЗГҮЦ

⁴ Бусад өр төлбөр – Банкууд дахь урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар, хуриятлуулж тооцсон хүүний өглөг

⁵ Бусад хөрөнгө – Орлогын шилжүүлэг, улсын төсвийн тусгай данс, улсын төсвийн хадгаламж, орон нутгийн төсөв

Зураг 4. Банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



Банкны системийн ЗГЦЗ-ийн хэмжээ 2013 оны 5 дугаар сараас хойш тогтмол нэмэгдэх болсон үндсэн шалтгаан нь Чингис бондын хөрөнгийн зарцуулалт болон ЗГҮЦ-ны арилжаа байна. Тайлант улирлын эцэст тус 2 хүчин зүйл нь ЗГЦЗ-ийн хэмжээг 1.5 их наяд төгрөгөөр буюу 68 хувиар өсгөх нөлөөлөл үзүүлжээ.

ЗГЦЗ-ийн тайланг банкуудаар болон системийн хэмжээгээр Хавсралт 1-д үзүүлэв.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

/сая төгрөгөөр/

ДАНС	БАНКУУД	Банкууд	Улирлын өсөлт /хувь/	Монголбанк	Улирлын өсөлт /хувь/	БҮГД ДҮН	Улирлын өсөлт /хувь/
1. Засгийн газрын өртөлбөр		1,822,988.3	33.4	-	-	1,822,988.3	33.4
Урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар		2,675.0	(13.1)	-	-	2,675.0	(13.1)
ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас		392,990.1	(31.1)	-	-	392,990.1	(31.1)
ЗГ-ын дунд хугацаатай үнэт цаас		1,387,321.8	83.1	-	-	1,387,321.8	83.1
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг		40,001.4	11.8	-	-	40,001.4	11.8
Засгийн газрын зээл		-	-	-	-	-	-
ЗГ-ын бусад төрлийн өглөг		-	-	-	-	-	-
2. Засгийн газрын хөрөнгө		1,186,170.0	(2.7)	1,692,783.7	(30.2)	2,878,953.7	(21.0)
Улсын төсөв		1,182,255.1	(2.3)	1,692,783.7	(30.2)	2,875,038.8	(20.9)
Улсын төсвийн төгрөгийн харилцах		-	-	807,145.0	81.4	807,145.0	79.9
Улсын төсвийн төгрөгийн хугацаатай хадгаламж		1,056.4	(98.5)	-	-	1,056.4	(98.5)
Улсын төсвийн төгрөгийн хугацаагүй хадгаламж		52.4	81.1	-	-	52.4	81.1
Улсын төсвийн төгрөгийн нөөц		-	-	386,367.4	3.5	386,367.4	3.5
Улсын төсвийн валютын нөөц		-	-	3,796.3	100.0	3,796.3	100.0
Улсын төсвийн валютын харилцах		-	-	461,068.6	(79.4)	461,068.6	(70.4)
Улсын төсвийн валютын хугацаатай хадгаламж		264.7	100.0	-	-	264.7	100.0
Улсын төсвийн валютын хугацаагүй хадгаламж		-	(100.0)	-	-	-	(100.0)
Улсын төсвийн валютын данс (төсөл)		-	-	25,151.1	40.6	25,151.1	131.9
Орлогын шилжүүлэг (төгрөг)		17,602.9	(5.7)	-	-	17,602.9	(5.7)
Орлогын шилжүүлэг (валют)		10,268.3	(1.0)	-	-	10,268.3	(1.0)
Нийгмийн даатгал (төгрөг)		565,635.1	20.1	-	-	565,635.1	20.1
Нийгмийн даатгал (валют)		-	-	-	-	-	-
Тусгай данс (төгрөг)		41,489.7	(20.6)	-	-	41,489.7	(20.6)
Тусгай данс (валют)		5,829.2	(75.5)	-	-	5,829.2	(75.5)
Засгийн газрын санхүүжилт		540,056.3	(4.1)	-	-	540,056.3	(4.1)
Засгийн газрын авлага (KFW II)		-	-	7,616.6	0.7	7,616.6	0.7
Хуримтлуулж тооцсон хүүний авлага		-	-	1,638.8	(94.0)	1,638.8	(94.0)
Өр барагдуулах албатай хийх тооцоо		-	-	-	-	-	-
Орон нутгийн төсөв		3,914.9	(50.6)	-	-	3,914.9	(50.6)
Орон нутгийн тусгай данс (төгрөгийн)		3,225.7	(57.5)	-	-	3,225.7	(57.5)
Орон нутгийн тусгай данс (валютын)		689.2	111.4	-	-	689.2	111.4
3. ЗГ-ын цэвэр зээл (1-2)		636,818.3	330.0	(1,692,783.7)	30.2	(1,055,965.4)	53.6

Эх үүсвэр: Монголбанк болон банкуудын тайлан тэнцэл